

ЭМИЙН ЭМЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРМЫН ТӨСӨЛ

Нэг. Нийтлэг зүйл

1.1 Эмнэлэгт эмийн эмчилгээг зохицуулах хороо (цаашид “хороо” гэх) болон бичил биетний эсрэг эмийн дэд хорооны ажиллах бүрэлдэхүүн, түүний үйл ажиллагааны эрх, үүргийг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Хорооны зорилго нь эмнэлэгт үйлчлүүлэгч эдийн засгийн үр ашигтай, чанартай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэх тогтолцоог хангах, эмийн сонголт, түгээлт, хадгалалт, хэрэглээ, хангамж хүртээмжид хяналт тавих, нянгийн тэсвэржилтийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авах, мэдрэг чанарын зүй тогтлыг тандах, судлах, эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллахад оршино.

1.3 Хороо нь “Эрүүл мэндийн тухай хууль”, “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичиг, бусад хууль тогтоомж, стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

1.4 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар, 40-өөс дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд эмийн эмчилгээг зохицуулах хороотой байна.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.1 Эмнэлгийн хүчин чадал, хүний нөөцийн хангамжаас хамааран хорооны бүрэлдэхүүн нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:

2.1.1 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг (ор бүхий)-т эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйчид, чанарын албаны дарга, тасгийн эрхлэгч нар, лабораторийн болон нян судлаач эмч, халдвар судлаач эмч, статистикч эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтан (9-өөс доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.1.2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газарт эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйчид, чанарын албаны дарга, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч, санхүүгийн асуудал эрхэлсэн удирдах албан тушаалтны төлөөлөл бүхий (7-оос доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.1.3 40-өөс дээш ор бүхий хувийн хэвшлийн эмнэлгүүд эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмнэлзүйн эм судлаач, эмнэлзүйн эм зүйчид, чанарын менежер, нарийн мэргэжлийн эмч нар, лабораторийн болон нян судлаач эмч, сувилахуйн арга зүйч зэрэг (5-аас доошгүй) гишүүдээс бүрдэнэ.

2.2 Хороог эмчилгээ эрхэлсэн орлогч дарга тэргүүлэх бөгөөд нарийн бичгийн даргаар эм зүйн албаны дарга эсхүл мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан эм зүйч ажиллана

2.3 Эмийн эмчилгээний хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг эмнэлгийн дарга баталж, шаардагдах зардлыг жил бүр төсөвт тусган, санхүүжүүлнэ.

2.4 Хороо нь дэргэдээ “Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг өөрийн эмнэлгийн нөхцөлд тохируулан боловсруулж, хэрэгжүүлэх баг” буюу бичил биетний эсрэг эмийн дэд хороо”-той байна.

2.5 Бичил биетний тэсвэржилттэй тэмцэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, мэдрэг чанарын зүй тогтлыг тандах, судлах;

2.6 Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээний талаарх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг дээшлүүлэх, нянгийн эсрэг эмийн эмчилгээний үндэслэл, жор бичилтийг сайжруулах сургалтыг зохион байгуулах

2.7 Бичил биетний эсрэг эмийн дэд хорооны бүрэлдэхүүнд халдвар судлаач эмч, нян судлаач эмч, эмнэлзүйн эм зүйч болон чанарын менежер , сувилахуйн албаны төлөөлөл ажиллана.

2.8 Эмийн эмчилгээг зохицуулах хорооны гишүүдийн журамд заасан чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтод тусгаж оруулах

Гурав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны эрх, үүрэг

3.1 Хороо нь дараах эрх эдэлнэ.

3.1.1 Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалт, зонхилон тохиолдох өвчний оношилгоо, эмчилгээний заавар, бодлогоор бүртгэх эмэнд санал өгөх;

3.1.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шинэ эм нэвтрүүлэх, эмчилгээнд хэрэглэж байсан эмийг ижил үйлчилгээтэй эмээр солих, зарим эмийн хэрэглээнд нас, тунгийн хязгаарлалт хийх, эмчилгээний үр дүнгүй эмийг эмчилгээнээс хасах тохиолдолд Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт мэдээлэх, шаардлагатай тохиолдолд Хүний эмийн зөвлөлд асуудал дэвшүүлэх

3.1.3 Тендерээр худалдан авч байгаа эмийн сонголт, чанар, зарцуулалт, гэрээний хэрэгжилтэд улирал бүр хяналт тавих, биелэлтийг үнэлэх;

3.1.4 Эмийн эмчилгээний тасалдлыг хянах, үйлчлүүлэгчээр авчруулж эмчилгээнд хэрэглэсэн эмийг эргүүлэн төлөх асуудлыг эмнэлгийн удирдлагад дэвшүүлэх;

3.1.5 Нянгийн тэсвэржилт, мэдрэг зүйн тогтлыг судлан тандахад эмч, эмнэлгийн мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.6 Нянгийн эсрэг эмэнд тэсвэржихээс сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдварыг таслан зогсоох, эрсдэлийг бууруулах, анхаарал татаж буй нянгийн эмнэлзүйн сорилт бүхий хяналтыг сайжруулах талаар салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, харилцан мэдээлэл солилцох;

3.1.7 Эмнэлэгт эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар санал, зөвлөмж гаргах;

3.1.8 Эмийн чанар, аюулгүй байдал, эмчилгээний идэвх, хүртээмж, төлөвлөлт, үр дүнг судлах, хянах, үнэлэх, эмчилгээний болон эдийн засгийн үр ашиггүй хэрэглээг бууруулах, нотолгоонд суурилан сонгох, эмчилгээ, оношилгооны зааврыг мөрдүүлэх,

зохистой хэрэглээг төлөвшүүлэх, үр дүнг байгууллагын удирдлагад тогтмол танилцуулах;

3.1.9 Хорооны ажлыг гүйцэтгэхэд эмнэлгийн эмч мэргэжилтэнг татан оролцуулах;

3.1.10 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх талаар улс, орон нутаг, байгууллагын түвшний хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтад оролцох, зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах;

3.2 Хороо дараах үүрэг гүйцэтгэнэ.

3.2.1 Тухайн эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эмийн жагсаалтыг Үндэсний зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад үндэслэн боловсруулах, батлан мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.2 Нянгийн эсрэг эмийн бодлого болон нянгийн эсрэг эмийн мэдрэг чанарыг тодорхойлсон дүнд үндэслэн нянгийн эсрэг эмийн жагсаалтыг боловсруулах, шинэчлэх, батлуулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх;

3.2.3 Эмнэлэгт антибиограм боловсруулан, тодорхой давтамжтайгаар шинэчлэх, батлуулах, түгээх;

3.2.4 Нотолгоонд суурилсан, нянгийн эсрэг эмийн эмчилгээний удирдамж, зааврыг нянгийн эсрэг эмийн бодлоготой уялдуулан боловсруулах, шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.5 Нянгийн эсрэг эмийн бодлогын үр дүнг үнэлэх;

3.2.6 Эмийн эмчилгээний үр дүнг тооцон эмийн хэрэглээг үнэлэх (ABC, VEN, DDD аргачлалын дагуу), эмчилгээний болон эдийн засгийн үр ашиггүй хэрэглээг бууруулах, эмийн үнэ, эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хяналт, судалгааг хийн, үр дүнг байгууллагын удирдлагад хагас жил тутам тайлагнах;

3.2.7 Эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх үйл ажиллагааг зохион байгуулах, холбогдох журмын дагуу гаж нөлөөний мэдээллийг хэлэлцэн, үнэлж Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт хүргүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлсэн цахим бүртгэл, санг бүрдүүлэх;

3.2.8 Гаж нөлөө үүсгэх өндөр эрсдэлтэй эмийн жагсаалтыг эмнэлгийн тусламж, үйлчилгээний онцлогтоо тохируулан гаргаж, жагсаалтад орсон эмийн гаж нөлөө илэрсэн үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны заавар боловсруулан баталж, мөрдүүлэх;

3.2.9 Эмийн хэрэглээтэй холбоотой тохиолдож болзошгүй эрсдэл, эмчилгээний алдаа дутагдлаас сэргийлэх, түүнийг арилгах арга хэмжээг зохион байгуулах;

3.2.10 Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх аргачлал, гарын авлага, удирдамжуудыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

3.2.11 Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, үр дүнг сайжруулах, хяналт тавьж ажиллах;

3.2.12 Эмнэлгийн мэргэжилтнийг шинэ эмийн мэдээллээр хангах, эмийн эмчилгээг оновчтой, эдийн засгийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөх чадварыг бий болгох ажлыг зохион байгуулах, удирдлага арга зүйгээр хангах;

- 3.2.13 Нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээний талаарх эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, дадлага, хандлагыг системтэй дээшлүүлэх, нянгийн эсрэг эмийн эмчилгээний үндэслэл, жор бичилтийг сайжруулах сургалтыг зохион байгуулах;
- 3.2.14 Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй болон амбулаториор үйлчлүүлэгчдэд эмийн хэрэглээний талаарх мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах;
- 3.2.15 Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагаа, шийдвэр, зөвлөмжийг удирдлага, эмч, мэргэжилтэнд ил тод нээлттэй хүргүүлэх;

Дөрөв. Бичил биетний эсрэг эмийн дэд хорооны үүрэг

4.1 Нянгийн эсрэг эмийн хэрэглээг тогтмол хянаж, нянгийн мэдрэг чанарын зүй тогтлыг судлан тандах, антибиограм боловсруулах, шаардлагатай арга хэмжээг авч, үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тайлагнах;

4.2 Бичил биетний эсрэг эмийн дэд хорооны ахлагч нь антибиотикийн асуудал хариуцсан эм зүйч байна.

4.3. Бичил биетний эсрэг эмийн хөтөлбөрийг удирдан ажиллана.

4.4. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны гишүүн байна;

4.5. Бичил биетний эсрэг эмийн хөтөлбөрийн төлөвлөлт, менежментийг хариуцан ажиллах

Бичил биетний эсрэг эмийн хөтөлбөрийн жил тутмын төлөвлөгөөг боловсруулах, төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих;

4.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулахад оролцох;

4.7. Нянгийн эсрэг эмийн хэрэглээ, хамаарлын үнэлгээг хагас бүтэн жилээр хийх ажлыг зохион байгуулах, үр дүнг хороо болон эмнэлгийн удирдлагад тайлагнах;

4.8 Дэд хорооны гишүүдийн хамт сургалт, судалгааны ажил хийх зэрэг үйл ажиллагааг арга зүйгээр хангаж, хэрэгжүүлнэ

4.2 Нян судлаач эмч

4.2.1 Нянгийн тэсвэржилтийн шинжилгээг хийх багаж, тоног төхөөрөмж, оношлуур зэргийн хүртээмжтэй байлгах талаар эмнэлгийн удирдлагад мэдээлэх;

4.2.2 Антибиограм болон нянгийн тэсвэржилтийн тандалтын мэдээллийг холбогдох эмч, эмнэлгийн мэргэжилтэнд түгээх;

4.2.3 Нянгийн эсрэг эмийн мэдрэг чанарын шинжилгээний дүнг WHONET программд өдөр бүр мэдээлэх, хариу мэдээллийг /ХӨСҮТ/-өөс хүлээн авч, дэд хорооны ахлагчид мэдээлэх;

4.2.4 Шаардлагатай тохиолдолд түргэвчилсэн шинжилгээг нэвтрүүлэх;

4.2.5 Олон эмэнд тэсвэртэй нян илэрсэн тохиолдол бүрийг дэд хорооны ахлагч, холбогдох мэргэжилтэнд шуурхай мэдээлэх;

4.2.6 Бусад шинжилгээтэй харьцуулан таамаг нянгийн эсрэг эмийн эмчилгээг сонгоход шаардлагатай мэдээ, мэдээллээр эмч, мэргэжилтэнг хангах.

4.3 Нянгийн тэсвэржилтийн асуудал хариуцсан эм зүйч

- 4.3.1 Нянгийн тэсвэржилтийг бууруулах, хөтөлбөрийн үйл ажиллагааг ахлан, тэргүүлэх үүрэг гүйцэтгэх;
- 4.3.2 Нянгийн тэсвэржилтийг бууруулах, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, багийн бусад гишүүдтэй эмнэлзүйн тусламж үйлчилгээг үзүүлэхэд хамтарч ажиллах;
- 4.3.3 Эмнэлзүйн удирдамж, эмийн эмчилгээ болон бусад холбогдох дүрэм, журам боловсруулахад оролцох, шинэ антибиотик эмийн эмчилгээг хянах;
- 4.3.4 Хөтөлбөрийн интервенцид хамрагдах эмчлүүлэгчийг тодорхойлж сонгох;
- 4.3.5 Нянгийн эсрэг эмийн эмчилгээг зохицуулах, зохицуулах, тухайлбал : Өргөн хүрээний үйлдэлтэй нянгийн эсрэг эмээс явцуу хүрээний үйлдэлтэй эмэнд шилжүүлэх эсвэл эмийн хэлбэрийг өөрчлөх буюу тарилгын эмийн хэлбэрээс уух хэлбэрт шилжүүлэх, шаардлагагүй нянгийн эсрэг эмийг зогсоох, хавсарсан эмчилгээний талаар үнэлгээ хийж хянах;
- 4.3.6 Хяналттай хэрэглэх нянгийн эсрэг эмийн жагсаалтыг халдвар судлаач эмч, нян судлаач эмчтэй хамтран батлах, боловсруулах, хэрэгжилтэд үнэлгээ хийх;
- 4.3.7 Нянгийн эсрэг эмийн хэрэглээ болон тандалтын судалгааг хариуцах. Үүнд:
- 4.3.7.1 Эмнэлгийн нянгийн эсрэг эмийн хэрэглээ, зарцуулалт антибиотик эмчилгээний талаар дэд хороо, эмийн эмчилгээг зохицуулах хороо, эмч нарт эргэн мэдээлэх, мэдэгдэх;
- 4.3.7.2 Удирдамжийн дагуу эмчилгээ хийгдэж буй эсэх;
- 4.3.7.3 Эмийн эмчилгээний алдааг тандаж илрүүлэх, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 4.3.7.4 Эмнэлгийн болон үндэсний түвшний тандалтын мэдээ мэдээлэл, тоо баримт, гаргах, цуглуулах, мэдээний сан бүрдүүлэх;
- 4.3.7.5 Эмнэлгийн нянгийн эсрэг эмийн хэрэгцээ, нөөц бүрдүүлэлтэд шаардлагатай тоо баримт цуглуулж, мэдээний сан бүрдүүлэх, тооцоолол хийхэд оролцох;
- 4.3.7.6 Эмнэлзүйн удирдамжийн болон эмчилгээний үр дүн, эмчилүүлэгчийн биеийн байдал сайжирсан эсэх, эдийн засаг, санхүү, нянгийн тэсвэржилтийн байдал, хөдлөл зүйг хянах;

4.4 Халдвар судлаач эмч болон бусад гишүүд

- 4.4.1 Эмэнд тэсвэртэй бичил биетний халдвараас сэргийлэхтэй холбоотой гарын авлага, удирдамжуудыг нянгийн тэсвэржилт, хөдлөл зүйтэй уялдуулан боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;
- 4.4.2 Нянгийн тэсвэржилтийг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах;
- 4.4.3 Дэд хорооны болон хорооны гишүүдтэй хамтран эмэнд тэсвэртэй бичил биетний халдварын сэргийлэлт, хяналтын талаарх хурал, зөвлөгөөн, ярилцлага, сургалтыг зохион байгуулах, санал, зөвлөмж гаргах.

Тав. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан мэдээг ирүүлэх

5.1 Тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, амаржих газрын эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хавсралтаар баталсан маягтын дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

5.2 Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг болон ор бүхий хувийн эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороо нь эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээг сар бүр дотооддоо гаргаж, тушаалын хавсралтаар баталсан маягтын дагуу бүтэн жилээр нэгтгэн гаргаж, эмнэлгийн тэмдгээр баталгаажуулан харьяа Эрүүл мэндийн газартаа дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

5.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь эмийн эмчилгээг зохицуулах хорооны нэгтгэсэн дүнг, тайлангийн хамт Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор бичгээр болон асуудал хариуцсан мэргэжилтний цахим хаягаар ирүүлэх;

Зургаа. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах

6.1 Эмийн эмчилгээг зохицуулах хорооны үйл ажиллагааг үнэлэх, зохицуулах ажлыг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүд хариуцан ажиллана. Үүнд:

6.1.2 Хорооны үйл ажиллагааны тайлан, мэдээг нэгтгэн дүгнэх;

6.1.3 Тайлан, мэдээтэй холбоотой шаардлагатай зөвлөмжийг эмнэлэг бүрд мэдээлэх;

6.1.4 Тушаалын хавсралтаар батлагдсан маягтын дагуу ирүүлсэн статистик мэдээг нэгтгэн, тухайн жилийн 2 дугаар улиралд багтаан Хүний эмийн зөвлөлийн хуралд танилцуулах;

6.1.5 Эмнэлгүүдийн эмийн эмчилгээг зохицуулах хороотой хамтран хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах.

6.1.6 Эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг холбогдох дээд шатны байгууллага болон магадлан итгэмжлэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагад хүргүүлэх

6.1.7 Эмийн эмчилгээний зохицуулах хорооны 6-р хавсралтаар батлагдсан шалгуураар өөрийн үйл ажиллагааг үнэлж, холбогдох журмын дагуу тайлангийн хамт 5.1, 5.2, 5.3-д заасны дагуу ирүүлэх

Эрүүл мэндийн сайдын оны
..... сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

Эмнэлгийн эмийн хэрэглээний талаарх мэдээ

Эмнэлгийн нэр.....

..... он

№	Үзүүлэлт	Тоо/хувь
1	Нийт хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчийн тоо	
2	Дундаж ор хоног /эмчлүүлсэн хугацаа/	
3	Эмчилгээнд нэг зэрэг хэрэглэсэн эмийн нэр төрлийн дундаж тоо	
4	Нийт хэрэглэсэн эмэнд антибиотик эмийн эзлэх хувь	
5	Нийт хэрэглэсэн эмэнд тарилгын эмийн эзлэх хувь	
6	Нийт хэрэглэсэн эмэнд зайлшгүй шаардлагатай эмийн эзлэх хувь	
7	Нийт хэрэглэсэн эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо	
8	Эмчилгээ оношилгооны удирдамжын дагуу эмчилгээнд хэрэглэсэн эмийн эзлэх хувь	
9	Хэвтэн эмчлүүлэх хугацаанд хэрэглэсэн эмийн дундаж үнэ /эмнэлгийн хэрэгсэл оруулан тооцох/	
10	Хэвтэн эмчлүүлэх хугацаанд үйлчлүүлэгчийн ар гэрээс авч эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн нэр төрөл	
11	Өвчтөнөөр авчруулж эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн эмийн үнэ	

Эмийн хэрэглээний мэдээ гаргасан:

Албан тушаал

Холбогдох утасны дугаар, цахим шуудан

Эрүүл мэндийн сайдын оны
..... сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 3 дугаар
хавсралт

Эмнэлгийн нянгийн эсрэг эмийн хэрэглээний талаарх мэдээ

Эмнэлгийн нэр.....

..... он

№	Үзүүлэлт	Тоо/хувь
1	Нянгийн эсрэг эм хэрэглэхээс өмнөх мэдрэг чанар тодорхойлсон шинжилгээний нийт тоо	
2	Эмчилгээнд хэрэглэсэн эмэнд антибиотик эмийн эзлэх хувь /нэр төрөл/	
3	Тарилга хэлбэрээр хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн эзлэх хувь	
4	Нянгийн эсрэг эмэнд илэрсэн гаж нөлөөний тоо	
5	Нийт хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн нэр төрлөөс ЗШЭ-ийн эзлэх хувь	
6	Нэг үйлчлүүлэгчид хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн нэр төрлийн дундаж тоо	
7	Урьдчилан сэргийлэх зорилгоор нянгийн эсрэг эми хэрэглэсэн өвчтөний тоо	
8	Нянгийн эсрэг эмийн эмчилгээний дундаж хугацаа	
9	Нянгийн эсрэг эмийн эмчилгээнд тарилгын хэлбэрээс уух хэлбэр лүү шилжүүлсэн өвчтөний тоо	
10	Нэг хэвтэн эмчлүүлэх хугацаанд эмчилгээнд хэрэглэсэн нянгийн эсрэг эмийн дундаж үнэ	

Эмнэлэгт тухайн жилд хэрэглэгдсэн антибиотик эмийн жагсаалт

АТС код	Эмийн ОУ-ын нэршил	Эмийн худалдааны нэршил	Эмийн хэлбэр	Эмийн тун	Хэрэглэсэн тоо ширхэг
J01GB06	Амикацин				
J01CA04	Амоксициллин				
J01CA04	Амоксициллин				
J01CR02	Амоксициллин Ферментийг хориглогч				
J01CR02	Амоксициллин Ферментийг хориглогч				
J01CA01	Ампициллин				
J01CR01	Ампициллин				
J01CE08	Бензатин пенициллин				
J01CE01	Бензилпенициллин				
J01DB04	Цефазолин				
J01DE01	Цефепим				
J01DD62	Цефоперазон нийлмэл найрлагатай				
J01DD01	Цефотаксим				
J01DE02	Цефпиром				
J01DD02	Цефтазидим				
J01DD04	Цефтриаксон				
J01DC02	Цефуроксим				
J01DC02	Цефуроксим				
J01BA01	Хлорамфеникол				
J01BA01	Хлорамфеникол				
J01MA02	Ципрофлоксацин				
J01MA02	Ципрофлоксацин				
J01CF02	Клоксациллин				
J01CF02	Клоксациллин				
J01FA01	Эритромицин				
J01FA01	Эритромицин				
J01FA01	Эритромицин				
J01GB03	Гентамицин				

J01DH51	ферментийн хориглогч				
J01MA12	Левифлоксацин				
J01MA12	Левифлоксацин				
J01DH13	Меропенем				
J01XD01	Метронидазол				
J01XD01	Метронидазол				
J01FA03	Мидекамицин				
J01FA03	Мидекамицин				
J01MA14	Моксифлоксацин				
J01FA03	Кларитромицин				
	Бусад				

Нянгийн эсрэг эмийн хэрэглээний мэдээ гаргасан:

Албан тушаал

Холбогдох утасны дугаар, цахим шуудан

Эрүүл мэндийн сайдын оны
..... сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 4 дүгээр хавсралт

Эмнэлгийн тэсвэржсэн нянгийн талаарх мэдээ

Эмнэлгийн нэр.....

.....ОН

№	Үзүүлэлт		
Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон хүний тоо			
1	Антибиотик мэдрэг чанар тодорхойлсон дүн	Мэдрэг %	Мэдрэг бус %
2	Пенициллины бүлэг / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
3	Макролидын бүлэг / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
4	Цефалоспорины бүлэг / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
5	Тетрациклины бүлэг / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
6	Аминогликозидууд / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
7	Карбапенемүүд / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
8	Липопептидүүд / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
9	Оксазолидон / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		
10	Бусад / антибиотикийн нэр тус бүрээр дурдах/		

Жич: Илэрсэн нян бүрээр хүснэгтийг бөглөн ирүүлнэ үү.

Эмнэлгийн тэсвэржсэн нянгийн мэдээ гаргасан:

Албан тушаал

Холбогдох утасны дугаар, цахим шуудан

Эрүүл мэндийн сайдын оны
..... сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 5 дугаар хавсралт

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан

Эмнэлгийн нэр.....

..... он

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны удирдлага, зохион байгуулалтын талаарх
товч танилцуулгыг бичих

№	Үйл ажиллагааны чиглэл	Хийсэн ажил	Хүрсэн үр дүн	Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тулгарсан бэрхшээл
1	Эм зүйн тусламж үйлчилгээнд чанар, аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулан батлуулж, дүн шинжилгээ хийж ажиллах			
2	Өндөр эрсдэлтэй эм, ижил харагддаг, ижил дуудагддаг эмүүдийн хэрэглээнд тасаг, нэгжид хяналт тавих, эмч эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил арга зүйгээр хангах			
3	МСНЭ хэрэгцээ, хэрэглээнд хяналт тавих			
4	Эм зүйн тусламж, үйлчилгээний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн, арга хэмжээ авч ажиллах			
5	Эмнэлгийн эмийн жагаалт дарь эмийн тоо, жагсалтын бус эмийн хэрэглээний мэдээлэл, шалтгаан			
6	Нянгийн тэсвэржилтийн хөдлөл зүй			
7	Эмийн үйлдвэрлэгчээс заасан хадгалалтын нөхцөл мөрдөлт, түүний хяналтыг хийх, (2 ⁰ С-8 ⁰ С, 8 ⁰ С,- 15 ⁰ С болон тасалгааны хэмд хадгалдаг эмүүдийн нэр, тоо, бүртгэл			
8	Эмийн чанартай холбоотой асуудлаар гаргасан үйлчлүүлэгчийн гомдол, саналд			

	дурьдагдсан эмүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл			
9	Явцуу хүрээний эмчилгээний индекс бүхий эмийн хэрэглээний мэдээлэл			
10	Эмчилгээнд дасал үүсгэсэн эмийн хэрэглээний мэдээлэл			
11	Тухайн жилд хэрэглэгдсэн үндэсний ЗШЭ-ийн жагсаалтад багтсан эмийн фармакологийн бүлэг, хэрэглээний хувь			
12	Удирдамжийн бус эмийн хэрэглээний хувь% нэр төрөл, шалтгаан			
13	Эмнэлэгт хийсэн эмийн таниулах үйл ажиллагааны зохион байгуулалт, бүртгэл			
14	Эмийн эмчилгээний үр дүн, эмийн хэрэглээ, эмийн эмчилгээний чанар, өртөг зардлын талаар хийсэн үнэлгээ болон судалгаа хийсэн үнэлгээ /судалгааны дүрг хавсаргана/			
15	Эмийн зохистой хэрэглээний сургалт, сурталчилгааг улирал бүр зохион байгуулж тайлан мэдээг, нэгтгэж ирүүлэх			
16	Жорын маягт, жор бичилтийн стандартын мөрдөлт, жорын маягтын хангалт, хүртээмж, жор бичилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ			

Эмийн эмчилгээг зохицуулах хорооны тайлан бичсэн:

Албан тушаал.....

Холбогдох утасны дугаар, цахим шуудан

Эрүүл мэндийн сайдын оны
..... сарын-ны өдрийн
..... дугаар тушаалын 6 дугаар хавсралт

ЭЭЗХ-ны үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх шалгуур

ЭЭЗХ нь өөрийн үйл ажиллагааг бүтэн жилээр үнэлж, тайлангийн хамт ирүүлэх

Д/д	Үнэлэх шалгуур	Тийм	Үгүй
1	ЭЭЗХ-ны зорилго, зорилт, үйл ажиллагаа болон хорооны гишүүдийн тухай мэдээллийг багтаасан бичиг баримттай байх		
2	ЭЭЗХ-ны үйл ажиллагаанд зориулагдсан зардал төсөвлөгдсөн байх		
3	ЭЭЗХ-нд эмнэлэгт хэрэглэх эмийн сонголтыг хийх бүрэн эрх болон эмийг сонгох тогтоогдсон шалгууртай эсэх		
4	Эмнэлгийн эмийн жагсаалттай эсэх		
5	Эмнэлгийн эмийн жагсаалтаас эмийг хасах, нэмэх мөн жагсаалтын бус эм хэрэглэх шалгуурыг боловсруулан баримтжуулдаг эсэх?		
6	Эмнэлгийн эмийн жагсаалт дахь эмүүдийн хэдэн хувийг жороор олгох эм эзэлдэг талаар мэдээллийг боловсруулан гаргасан байх		
7	Зөвхөн өөрийн эмнэлэгт хэрэглэхээр боловсруулсан эмнэлзүйн удирдамжтай эсэх		
8	Эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилтийг үнэлэхийн тулд түүнд тусгагдсан эмийн хэрэглээний судалгааг хийсэн эсэх		
9	ЭЭЗХ нь эмийн талаарх мэдлэг олгох үйл ажиллагаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнд зохион байгуулдаг эсэх		
10	Эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан сургалт, мэдээлэл боловсруулсан эсэх		
11	Эрүүл мэндийн байгууллага эь эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан номын сантай эсэх		

12	Эмнэлгийн мэргэжилтнийг сургах тасралтгүй сургалтын тогтолцоо байгаа эсэх		
13	Эмийн талаарх мэдээлэл мэргэжилтнүүдэд нээлттэй байдаг эсэх		
14	Эмийн хэрэглээг сайжруулах арга хэмжээний талаарх судалгаа хийсэн эсэх		
15	Эмийн төсөв боловсруулахад ЭЭЗХ нь зөвлөгөө өгч, зардлыг хуваарилах үйл ажиллагаанд оролцдог эсэх		
16	ЭЭЗХ нь төлөөлөгчийн газар болон эмийн талаарх зар сурталчилгаатай холбоотой үйл ажиллагааг хянах, бодлого боловсруулсан ажилладаг эсэх		

*Хэрэв үгүй гэж хариулсан бол шалтгааныг дурдан бичиж ирүүлнэ үү